



УЛААНБААТАР ХОТЫН ЦЭВЭР АГААР ТӨСӨЛ ТӨСЛИЙН ДУГААР CWNB-01-A

ЭЦСИЙН ТАЙЛАН

“ГЭРИЙН ЗУУХНЫ ОДОО МӨРДӨГДӨЖ БАЙГАА
СТАНДАРТЫГ БҮРЭН ШАТАЛТТАЙ САЙЖРУУЛСАН
ЗУУХНЫ БОДИТ ҮЗҮҮЛЭЛТТЭЙ ОЙРТУУЛАН
ШИНЭЧЛЭН САЙЖРУУЛАХ
ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ”

Улаанбаатар Цэвэр Агаар Төсөл, ТӨСЛИЙГ УДИРДАХ
НЭГЖ- ийн захиалгаар



ШУТИС ЭХС-ийн Зуухны туршилт судалгааны төв боловсруулав.

Сүхбаатардүүрэг 8-р хорооБага тойруу-34,
ШУТИС-ийнхичээлийн 2-р байр
Утас:323579, Факс:976-11-323579, 99041705
Э-шуудан: Oidov_zh@Yahoo.com
Web хаяг:<http://www.must.edu.mn>

2016 оны 11 сарын 28

ТАЙЛАНГИЙН АГУУЛГА

Товчилсон үгсийн тайлбар	3
I. Оршил	4
II. Төслийн гүйцэтгэлийн хураангуй	5
III. Төслийн явцын тайлан 2-оос хойших зөвлөхийн үйл ажиллагаа	5
Хавсралт1.	6
Хавсралт 2.	
Хавсралт3.	
Хавсралт4.	

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ТАЙЛБАР

АХБ	- Азийн хөгжлийн банк
АББҮХ	- Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороо
БОГУУХГ	- Байгаль орчин, геологи, уул уурхайн хяналтын газар
БОГУУХХ	- Байгаль орчин, геологи, уул уурхайн хяналтын хэстэс
БОНХАЖЯ	- Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам
ДБХГ	- Дэд бүтцийн хяналтын газар
ДТҮЭХ	- Дулааны техник үйлдвэрийн экологийн хүрээлэн
ЗБ	- Зөвлөх баг
ЗТСТ	- Зуухны туршилт, судалгааны төв
МХЕГ	- Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
НАЧА	- Нийслэлийн агаарын чанарын алба
НЗДТГ	- Нийслэлийн засаг даргын тамгын газар
НМХГ	- Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар
НЭМХ	- Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн
ОШХ	- Орчны шинжилгээний хэлтэс
СХЗГ	- Стандартчилал Хэмжил зүйн газар
СХЗГБОТХ	- Байгаль орчны техникийн хороо
СХЗГЭХТХ	- Эрчим хүчний техникийн хороо
ТУН	- Төслийн удирдах нэгж
УБ	- Улаанбаатар
УБЦАТ	- Улаанбаатар цэвэр агаар төсөл
ЦУОШГ	- Цаг уур, орчны шинжилгээний газар
ШУТИС	- Шинжлэх ухаан технологийн их сургууль
ЭМСЯ	- Эрүүл мэнд, спортын яам
ЭХС	- Эрчим хүчний сургууль
ЭХЯ	- Эрчим хүчний яам

I. ОРШИЛ

Дэлхийн банк/Олон улсын хөгжлийн ассоциациас авсан хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлж байгаа Улаанбаатар цэвэр агаар төсөл (УБЦАТ)-ийн хүрээнд “Гэрийн зуухны одоо мөрдөгдөж байгаа стандартыг бүрэн шаталттай сайжруулсан зуухны бодит үзүүлэлттэй ойртуулан шинэчлэн сайжруулах зөвлөх үйлчилгээ” ажлыг гүйцэтгэхээр ШУТИС-ийн Зуухны туршилт, судалгааны төв болон Улаанбаатар цэвэр агаар төслийн ТУНэгж харилцан тохиролцож, 2016 оны 4-р сарын 28-нд гэрээ байгуулсан.

Энэхүү гэрээний дагуу ШУТИС-ийн Зуухны туршилт, судалгааны төвийн зөвлөх баг ажлын удирдамжийг баримтлан судалгааны ажлыг гүйцэтгэж эхлэлийн, явцын 1 ба 2-р тайланг захиалагчид хүлээлгэн өгсөн.

Энэ төслийн явцын 2-р тайлангаас хойш стандартын төсөлд гол оролцогч талууд болон холбогдох яам, мэргэжлийн байгууллагууд, үйлдвэрлэгчдийн албан ёсны санал, шүүмж, зөвлөмжүүдийг нэгтгэн тусгаж MNS 5216: 2016 “Ахуйн хэрэглээний зуухны техникийн ерөнхий шаардлага, яндангаас гарах утааны найрлага дахь агаар бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга” стандартын эцсийн хувилбарыг боловсруулж СХЗГазарт илгээн эрчим хүчний стандартчилалын техникийн хороо болон үндэсний зөвлөлөөр оруулан хэлэлцүүлж батласан.

Монгол улсын Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуулийн 2-р бүлгийн 4.1, 6.2-т заасны дагуу одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа гэрийн буюу ахуй хэрэглээний зууханд хобогдох стандартуудыг шинэчилснээр гэр хорооллын айл өрхийн халаалтын хэрэгслээс ялгарч байгаа агаар бохирдуулдаг бодисын хэмжээнд тавигдах шаардлага өндөрсөж, агаарын бохирдлыг бууруулахад чухал ач холбогдолтой суурь баримт бичиг болж байгаа юм.

Энэ тайланд төслийн хүрээнд хийсэн ажлын хураангуй, англи, монгол хэл дээр бэлтгэсэн стандарт, СХЗГ-ын эрчим хүчний стандартчилалын техникийн хорооны хурлын тэмдэглэл, стандартыг баталсан үндэсний зөвлөлийн тогтоолыг оруулсан.

II. Төслийн гүйцэтгэлийн хураангуй:

- 2.1 ШУТИС-ийн Зуухны туршилт, судалгааны төв ба Улаанбаатар цэвэр агаар төслийн ТУНэгжийн хооронд байгуулсан гэрээний дагуу зөвлөх баг ажлын удирдамжийг баримтлан соролцогч талуудыг тодорхойлж, ажлын график, хүний нөөцийн хуваарилалт, стандарт боловсруулах арга аргачлалыг багтаасан эхлэлийн тайланг хүлээлгэн өгсөн.
- 2.2 Зөвлөх багийн гишүүдийн ажлын удирдамжийн дагуу 2-р үе шатны ажлын хүрээнд гол оролцогч талуудтай уулзаж, шаардлагатай мэдээлэл, тоо баримт, зуух солих хөтөлбөрийн баримт бичгүүдтэй танилцаж, холбогдох стандартууд, гэрийн зуухны туршилтын протоколуудыг харьцуулан судалж шинжлэн стандарт боловсруулах дэс дараалал тогтоосон.
- 2.3 Холбогдох талууд, судлаач эрдэмтэдийн төлөөллийг оролцуулан судалгааны үр дүн, стандартын төслийн хэлэлцүүлгийг 2 удаа хийж, гарсан саналуудыг стандартын төсөлд тусган гол оролцогч талууд болон холбогдох яам, мэргэжлийн байгууллагууд, үйлдвэрлэгчдэд илгээн тэдний албан ёсны санал, шүүмж, зөвлөмжүүдийг авч эцсийн хувилбарыг боловсруулан СХЗГ-ын эрчим хүчний ба Байгаль орчны стандартчилалын техникийн хорооны хурлаар хэлэлцүүлэн СХЗГ-ын үндэсний зөвлөлөөр оруулахаар илгээсэн.
- 2.4 MNS 5216: 2016 “Ахуйн хэрэглээний зуухны техникийн ерөнхий шаардлага, яндангаас гарах утааны найрлага дахь агаар бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга” стандартын эцсийн хувилбарын төслийг СХЗГ хүлээн аваад бүтцийн өөрчлөлтэй холбоотойгоор техникийн хороод болон үндэсний зөвлөлөөр зөвлөл 2016 оны 9-р сард хуралдахгүй 10, 11-р сард хуралдахаар төлөвлөсөн гэж 9-р сарын 6-нд албан бичгээр хариу өгсөн.
- 2.5 Иймд СХЗГ –ын дээрх албан бичгийг үндэслэн гэрээг 2016 оны 12-р сарын 31 хүртэл сунгасан.

III. Төслийн явцын тайлан 2-оос хойших зөвлөхийн үйл ажиллагаа

- 3.1 MNS 5216: 2016 “Ахуйн хэрэглээний зуухны техникийн ерөнхий шаардлага, яндангаас гарах утааны найрлага дахь агаар бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга” стандартын төслийн эцсийн хувилбарыг хянан англи хэл дээр орчуулах ажлыг хийж гүйцэтгэсэн.
- 3.2 MNS 5216: 2016 “Ахуйн хэрэглээний зуухны техникийн ерөнхий шаардлага, яндангаас гарах утааны найрлага дахь агаар бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга” стандартын эцсийн хувилбарын төслийг 2016 оны 11-р сарын 18-ны өдөр СХЗГ-ын эрчим хүчний стандартчилалын техникийн хорооны

хурлаар хэлэлцээд стандартын нэрийг MNS 5216: 2016 “Ахуйн хэрэглээний зуухны техникийн ерөнхий шаардлага” гэж өөрчлөн зарим алдааг засаад СХЗГ-ын үндэсний зөвлөлийн хурлаар оруулж хэлэлцүүлэн батлуулахаар дэмжсэн.

- 3.3 СХЗГ-ын эрчим хүчний техникийн хорооны хурлаас гишүүдийн гаргасан санал, зөвлөмжийн дагуу стандартын нэрийг MNS 5216: 2016 “Ахуйн хэрэглээний зуухны техникийн ерөнхий шаардлага” гэж өөрчилж, хэл найруулгын талаар зарим засвар хийгээд эрчим хүчний стандартчилалын техникийн хорооны нарийн бичгийн даргатай хамтран стандартын албан ёсны хэлбэрт оруулан СХЗГ-ын үндэсний зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх төслийг бэлэн болгосон.
- 3.4 СХЗГ-ын эрчим хүчний стандартчилалын техникийн хорооны хурлаар хэлэлцүүлсэн MNS 5216: 2016 “Ахуйн хэрэглээний зуухны техникийн ерөнхий шаардлага” стандартын эцсийн хувилбарын төслийг 2016 оны 11-р сарын 24-ны өдөр СХЗГ-ын үндэсний зөвлөлийн хурлаар хэлэлцээд батласан.
- 3.5 СХЗГ-ын үндэсний зөвлөлийн хурлаар хэлэлцэж батласан “Ахуйн хэрэглээний зуухны техникийн ерөнхий шаардлага” стандартын монгол, англи хэл дээр бичиж хавсаргав.
- 3.6 СХЗГ-ын эрчим хүчний техникийн хорооны хурлын тэмдэглэл, СХЗГ-ын үндэсний зөвлөлийн хурлын тогтоолыг хавсаргав.

Хавсралт 1
MNS 5216 : 2016

		Агуулга
1	Өмнөх үг	
2	Хамрах хүрээ	3
3	Норматив ишлэл	3
4	Нэр, томъёо тодорхойлолт	4
5	Техникийн шаардлага	7
6	Байгаль орчинд нөлөөлөх байдал буюу экологийн үзүүлэлтэнд тавигдах шаардлага	9
7	Аюулгүй ажиллагааны шаардлага	9
8	Турших арга	10
9	Туршилтын үр дүнг боловсруулах аргачлал	11
10	Туршилтын үр дүнгийн зөвшөөрөх алдаа	12
11	Туршилтын үр дүнг хэвийн нөхцөлд шилжүүлэх аргачлал	12
12	Туршилтын үр дүнг тайлагнах	13
13	Хаяглах	14
14	А хавсралт	15
15	Ном зүй	16

Өмнөх үг

Стандартчилал, Хэмжил Зүйн Газар (цаашид СХЗГ гэх) Олон Улсын стандартчиллын бодлогыг төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран хэрэгжүүлдэг.

Тус газар нь тухайн салбарын улсын стандартын төсөл боловсруулах ажлыг техникийн хороогоор дамжуулан гүйцэтгэдэг. Техникийн хороогоор хэлэлцэж 75-аас доошгүй хувийн саналаар зөвшилцсөн стандартын төслийг Стандартчилал, Хэмжил Зүйн Үндэсний Зөвлөл (СХҮЗ)-ийн тогтоолоор баталснаар улсын хэмжээнд хүчин төгөлдөр болно.

Энэхүү стандартыг Улаанбаатар Цэвэр Агаар Төсөл, Төслийг удирдах нэгжийн “Гэрийн зуухны одоо мөрдөгдөж байгаа стандартыг бүрэн шаталттай сайжруулсан зуухны бодит үзүүлэлттэй ойртуулан шинэчлэн сайжруулах зөвлөх үйлчилгээ” төслийн хүрээнд зөвлөх баг боловсруулав.

Энэ стандартыг Эрчим хүчний техникийн хороо ба Байгаль орчны техникийн хороогоор хэлэлцэн зөвшилцөж, Стандарчилал, Хэмжилзүйн Үндэсний Зөвлөлийн тогтоолоор баталсан болно.

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ахуйн хэрэглээний зуух. Техникийн ерөнхий шаардлага.	MNS 5216 : 2016
The stoves for heating and cooking. General technical requirements.	MNS 5216:2002 ба MNS 5216-1:2011-ийн оронд

Стандартчилал, хэмжилзүйн үндэсний Зөвлөлийн 2016 оны 11-р сарын 24- ны өдрийн 50 дугаар тогтоолоор батлав.

Энэхүү стандарт 2017 оны 4- р сарын 1- ны өдрөөс эхлэн хүчинтэй.

Энэхүү стандартыг улсын бүртгэлд бүртгэсэн өдрөөс эхлэн норматив шаардлагыг заавал мөрдөнө.

1. Хамрах хүрээ

Энэ стандарт нь 3 кВт-аас- 15 кВт хүртэл чадалтай ахуй хэрэглээний зуух (цаашид зуух гэх)-ыг үйлдвэрлэх, импортлоход хамаарна. Энэхүү стандартаар Монгол гэр болон түүнтэй адилтгах сууцанд ашиглах хатуу түлшний зууханд тавих техникийн ерөнхий шаардлага, турших арга, гарах утааны найрлага дахь агаар бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээг тогтооно.

2. Норматив ишлэл

Энэхүү стандартад дараах иш татсан стандарт, баримт бичгийг хэрэглэсэн. Он заасан ишлэлийн хувьд зөвхөн иш татсан хэвлэлийг хэрэглэнэ. Он заагаагүй ишлэлийн хувьд тухайн стандартын хамгийн сүүлийн хэвлэл (нэмэлтийн хамт)-ийг хэрэглэнэ.

2.1 Монгол улсын үндэсний стандартчиллын тогтолцоо. 1-р хэсэг: Техникийн ажлын журам. MNS 1-1: 2006

2.2 Монгол улсын үндэсний стандартчиллын тогтолцоо. 2-р хэсэг: Стандартын бүтэц ба боловсруулах. MNS 1-2: 2006

2.3 ISO/IEC Удирдамж 1-р хэсэг. 2016. Техникийн ажлын журам.

2.4 ISO/IEC Удирдамж 2-р хэсэг. 2016. Стандартын бүтэц ба боловсруулах

2.5 www.estandard.mn сайт. Стандартыг хэрхэн бичих вэ? зөвлөмж

2.6 MNS4585:2016 Агаарын орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага

2.7 MNS 5568:2005, Шингэн түлшээр ажилладаг ахуйн хэрэглээний зуух. Техникийн ерөнхий шаардлага;

2.8 (BS EN 13240:2001, Хатуу түлшээр ажилладаг гэрийн зуух. Техникийн ерөнхий шаардлага ба шалгах арга.

3. Нэр, томъёо тодорхойлолт

Энэхүү стандартад дараах нэр томъёо, тодорхойлолтыг хэрэглэнэ.

3.1

ахуй хэрэглээний зуух

хатуу түлшийг шатааж гаргасан дулааныг Монгол гэр болон түүнтэй адилтгах сууцанд халаалт болон хоол бэлтгэх зориулалтаар ашиглах төхөөрөмж;

3.2

ашигтай зарцуулсан нэгж дулаанд харгалзах бохирдуулах бодисын хэмжээ

зуухны дулааны бүтээмж буюу ашигтай зарцуулагдаж байгаа 1 Гкал буюу 1 МДж дулаанд харгалзах агаар бохирдуулах бодисуудын хэмжээг мг/Гкал буюу мг/МДж нэгжээр илэрхийлнэ.

3.3

ашигт үйлийн коэффициент

Хатуу түлшийг шатаахад ялгарсан дулааны хэдэн хувийг ашигтай зарцуулж байгааг илэрхийлэх үзүүлэлт;

3.4

Бодит түлш

зууханд түлж байгаа төрөл бүрийн түлш

3.5

бохирдуулах бодисын массын агууламж

нэг шоо метр утаанд агуулагдаж байгаа бохирдуулах бодисын массын хэмжээ, мг/м³-ээр илэрхийлнэ.

3.6

бохирдуулах бодисын эзлэхүүний агууламж

нэг шоо метр утаанд агуулагдаж байгаа бохирдуулах бодисын эзлэхүүн, 1 см³/м³ = 1 ppm-ээр илэрхийлнэ.

ТАЙЛБАР: 1 ppm – хийн эзлэхүүний сая хуваасны нэг хэсэг, 10⁻⁶

3.7

бохирдуулах бодисын гаралтын зөвшөөрөгдөх дээд хэмжээ

ахуй хэрэглээний зуухнаас гарах утааны найрлага дахь агаар бохирдуулах бодисын хэмжээний дээд хязгаар буюу агаар мандлыг бохирдуулах эх үүсвэр бүрээс хаягдах хорт бодисын дээд хэмжээ.

ТАЙЛБАР: Энэ нь хэвийн нөхцөл дэх нэг шоо метр утаанд агуулагдаж байгаа бохирдуулах бодисын массын хэмжээ, мг/м³-ээр, эсвэл 1 кг жишмэл түлшний шаталтаас ялгарах (мг/кг.ж.т) болон 1 МДж дулаанд харгалзах (мг/МДж) хэмжээгээр илэрхийлэгдэх бөгөөд бусад эх үүсвэрийн хаягдалтай нэгдэж, тархасны дараа хүний амьсгалын түвшний агаар дахь агууламж нь хорт бодисын зөвшөөрөгдөх агууламжаас ихгүй байна.

3.8

галын хотол

түлшний шаталтын процесс дотор нь явагддаг, зуухны зориулалт болон тухайн түлшний шинж чанарт тохируулан зохион бүтээсэн эд анги;

3.9

гэрийн доторх агаарын температур

зуухны төвөөс 1.5 метр радиустай тойргийн дагуу шалнаас дээш 40 см зайд хэмжсэн агаарын дундаж температур;

3.10

дулааны бүтээмж

зуухны нэгж хугацаанд гаргасан дулааны хэмжээ

3.11

дулаан ялгаруулалт

зуухны галын хотолд түлшний шаталтаас үүсч байгаа дулааны энергийн хэмжээ;

3.12

дулааны нэрлэсэн хүчин чадал

үйлдвэрлэгчээс тогтоосон болон техникийн нөхцлийг хангасан түлшийг шатааж балансын туршилтаар лабораторийн нөхцөлд тодорхойлсон, зуухны гаргаж буй ашигтай зарцуулагдах дулааны нийт хэмжээ;

3.13

жишмэл түлш

29.3 МДж/кг буюу 7000 ккал/кг дулаан гаргах чадвар буюу илчлэгтэй түлш.

ТАЙЛБАР: Байгаль дээрх бүх төрлийн түлшний илчлэг буюу дулаан гаргах чадвар өөр өөр байдаг тул тэдгээрийг хооронд нь жишиж харьцуулахын тулд нэг утганд шилжүүлэх шаардлагын үүднээс олон улсын хэмжээнд хэрэглэх болсон ойлголт юм. Бодит түлшийг дараах байдлаар жишмэл түлшинд шилжүүлнэ.

$$V_{ж.т} = VxK = Vx(Q_i^r/7000) = Vx(Q_i^r/29.3) \quad (1)$$

Энд V , Q_i^r - бодит түлшний дулаан гаргах доод чадвар буюу илчлэг.

3.14

илүүдэл агаарын коэффициент, α

нэгж хэмжээний (1 кг) түлшний шаталтанд зарцуулсан агаарын бодит хэмжээг онолын хувьд шаардлагатай агаарын хэмжээнд харьцуулсан утга.

ТАЙЛБАР: Зуух тус бүрийн хийц, түлшний шаталтын нөхцлөөс хамаарч харилцан адилгүй өөр өөр байна.

3.15

нүүрстөрөгчийн дутуу ислийн ялгарал

зуухны яндангаар утаанд агуулагдаж гарах нүүрстөрөгчийн дутуу ислийн (CO) хэмжээ.

3.16

нэг кг түлшний шаталтаас үүсэх бохирдуулах бодисын хэмжээ

нэг кг бодит буюу жишмэл түлшний шаталтаас үүссэн утаан дахь агаар бохирдуулах бодисуудын хэмжээг мг/кг.т буюу мг/кг.ж.т нэгжээр илэрхийлнэ.

3.17

түлшний ам

зөвхөн түлш өгөх зориулалтаар ашиглагддаг нээх, хаах боломжтой нугас, түгжээ бүхий ам;

3.18

түлшин дэх үнсний агууламж

хатуу түлшний бүрэн шаталтын дараа үлдсэн усанд үл уусах бодис;

3.19

Түлшний илчлэг (дулаан гаргах доод чадвар),

Нэг кг түлшийг бүрэн шатаахад ялгарах нийт дулаанаас түүний чийглэгийг болон устөрөгчийн шаталтаас үүсэх усны уурыг ууршуулах дулааны хэмжээг хассаныг түүний илчлэг буюу дулаан гаргах доод чадвар гэнэ.

ТАЙЛБАР: Түлшний төрөл, бүтцээс хамааран шаталтаас ялгарах дулааны хэмжээ харилцан адилгүй байна.

3.20

тоосонцорын ялгарал

зуухны яндангаар утаанд агуулагдаж гарах тоосонцорын хэмжээ;

3.21

ул ширэм

түлшний үелсэн шаталт явуулах, шаталтанд шаардлагатай агаар нэвтрүүлэх, үнс буулгах зориулалтын нүхтэй галын хотлын доор байрлуулсан түлшний шаталтын дулааны хүчдэлийг тэсвэрлэх чадвартай ширмэн сараалж;

3.22

ул ширэмний хавирга

суурин болон салдаг байдлаар цутгагдсан ул ширэмний сараалж болж байгаа хавирга;

3.23

утааны температур

гэрийн тооноор яндан гарах цэгт хэмжсэн утааны температур;

3.24

үнсний сав

үнсний тосгуурын гадна гэр буюу зориулалтын хийц загвартай, хааж нээж болох амтай хэсэг;

3.25

үнсний саван дахь үлдэгдэл

үнсний тосгуурт хуримтлагдсан, тодорхой хэмжээний дутуу шатсан түлш агуулсан үнс;

3.26

үнсний тосгуур

ул ширэмнээс унасан үнсийг хуримтлуулах зориулалттай, үнсний савнаас сугалж авах боломжтой тусгай хэв маяг бүхий бариултай шургуулга хэлбэрийн сав;

3.27

халаах гадаргуу

түлшний шаталтаас ялгарах дулааныг гэрийн доторх агаарт дамжуулах гадаргуу;
ТАЙЛБАР: зуухны нийт гадна гадаргуу болон янданд холбогдох хэсэг гэрийн доторх агаарт дулаан өгөх учраас халаах гадаргуу гэж үзнэ.

3.28

Ханан пийшин

Гэртэй адилтгах сууцыг халаахад яндангаар хаягдах утааны хийн дулааныг ашиглах зорилгоор зуухнаас гарах утааны хийн замыг уртасган тоосгоор барьсан гурав ба түүнээс дээш хэвтээ болон босоо, холимог худагтай гадаргуугаараа халаах хэрэгсэл.

ТАЙЛБАР: Тухайн сууцны хэмжээ, дотоод зохион байгуулалтаас хамаарч ханан пийшингийн худгийн тоо хэмжээг тодорхойлон ашиглана.

3.29

хатуу түлш

байгалийн гаралтай ба зориуд үйлдвэрлэсэн хатуу эрдэс түлш түүнчлэн байгалийн болон үйлдвэрлэлийн аргаар боловсруулсан түлээ, модны төрөл бүрийн хаягдал, хүлрийн орцтой шахмал түлш;

3.30

хатуу эрдэс түлш

нүүрс, хүрэн нүүрс, коксжсон нүүрс, эдгээрээс гаргасан түлш;

3.31

хэвийн нөхцөл

Зуухны утааны даралт 101325 Па, температур 273 К байх нөхцөл

3.32

шаталтын үндсэн үе давхарга

зуухны галын хотолд түлш шатаж буйг илэрхийлэх улайссан цог нурмын хэмжээ;
ТАЙЛБАР: Шаталтын үндсэн үе давхаргыг үйлдвэрлэгч тодорхойлж болно.

3.33

шаталтыг тэтгэх агаар

түлшний шаталтыг тэтгэхийн тулд бүрэн болон хэсэгчлэн зарцуулах зориулалтаар галын хотолд өгч байгаа агаар;

3.34

шаталтын бүтээгдэхүүн (утаа)

түлш шатахад төхөөрөмжийн дотор шаталтын бүтээгдэхүүн болон үүсдэг хийн төлөвтэй бодис;

3.35

яндангийн таталт

утаа болон хүйтэн агаарын нягтын зөрүүгээр галын хотолд үүсгэх сийрэгжилт;

4. Техникийн шаардлага

4.1 Зуухны техникийн ерөнхий үзүүлэлтийг 1-р хүснэгтэд үзүүлэв.

4.2 Зуухны галын хотлын доторлогоог галд тэсвэртэй шавраар чанартай хийнэ.

4.3 Галын хотол, хүхээгийг үнс, хөөнөөс хялбар цэвэрлэх боломжтой байхаар зуухыг зохион бүтээнэ.

4.4 Зуухны галын хотол, утааны замд тэсрэлтээс хамгаалах хавхлага, утааны хий цэвэрлэх хэрэгслээр тоногдсон байж болно.

1-р хүснэгт. Зуухны техникийн ерөнхий үзүүлэлт

д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Зөвшөөрөгдөх хэмжээ	Тайлбар
1	Чадал	кВт	3-15	
2	АҮК	%	70	багагүй
3	Утааны таталт /галын хотлын сийрэгжилт/	Па	6-12	
4	Утааны температур	°С, дундаж температур	150	Хэвийн ажиллагааны үед

4.5 7 кВт-аас -15 кВт чадалтай зуухыг үйлдвэрлэгчийн зураг схем, ашиглалтын зааврыг үндэслэн ханан пийшинд холбож болно.

4.6 Зуух нь технологийн зураг, схемтэй, 4-өөс доошгүй жилийн баталгаатай байна.

4.7 Зуухны хийцэд тавигдах шаардлага

4.7.1 Зуухны ган хийц

4.7.1.1 Гагнуурын ажил, гагнуурын материал

Хэрэглэсэн материал буюу электрод, гагнуураар холбогдож байгаа эд ангийг тухайн гагнуурын төрөл, ангилалд тохируулан сонгоно.

4.7.2 Зуухны дотор хэсгийн цэвэрлэгээ

Нээлхий болон бөглөөг нээхэд хялбар, сойз, үлдэгдлийг хусах, хамах хэрэгсэлийг ашиглан утааны хийн талаас бүх гадаргууг шалгаж цэвэрлэхэд дөхөмтэй байна.

4.7.3 Зуухны дээд ширэм

Зуухны цагираг хэлбэрийн дээд ширэмнүүд чухал үүрэгтэй бөгөөд том цагирагны диаметр 300 мм-ээс багагүй байна.

4.7.4 Яндангийн холбох хэрэгсэл болон хаалт

Яндангийн хэвтээ холболтын хувьд хийн хоолойн холбогчийн урт нь 80 мм-ээс, босоо холболтын хувьд доод тал нь 25 мм-ээс тус тус доошгүй байна.

4.7.5 Зуухны янданд тавигдах шаардлага

Яндангийн диаметр 100 мм, гэрийн тооно буюу барилгын дээврээс дээш 700 мм-ээс дээш илүү гарахаар өндөр байх хэрэгтэй.

4.7.6 Ханан пийшинд тавигдах шаардлага

4.7.6.1 Хийцийн хувьд энгийн, байрлуулах ба өрж доторлоход бэрхшээл багатай, бат бөх бөгөөд эдэлгээ удаантай (Тоосгон пийшингийн ажиллах үлгэрчилсэн хугацаа нь 20-30 жил), зуух холбох хэсэг нь яндангийн таталтанд нөлөөлөхөөргүй утаа чөлөөтэй урсаж байх нөхцөлийг хангасан, эргэлт, булан тохой багатай байх хэрэгтэй.

4.7.6.2 Бүх гадаргуу нь жигд, ялангуяа доод хэсэг болон сүүлийн худгууд аль болох сайн халж, хоногийн бүх хугацаанд буюу дараагийн галлагаа хүртэл сууцны халаалтыг жигд барьж байх ёстой.

4.7.6.3 Зуухыг ханан пийшинд шулуун холбоход холбогчийн дотоод огтлол 110 мм х 110 мм – 140 мм х 140 мм, урт нь 100 мм-250 мм, өнцгөн холболтын дотор огтлол 140 мм х 140 мм-ээс багагүй, урт 250 мм хүртэл, 120-оос дээш градус налуу байна.

4.7.7 Үнсний сав

4.7.7.1 Үнсний сав нь шургуулга маягийн хэлбэртэй сугалж авахад саадгүй, ул ширэм болон хуримтлагдсан үнсний хоорондох зай анхдагч агаарын зарцуулалтыг

бууруулахгүйгээр түлшний хоёр удаагийн бүрэн цэнэглэлтээс үүссэн үнс, шааргыг хуримтлуулах багтаамжтай байна. Хэрэв үнсний саваар агаар оруулах зориулалттайгаар хийсэн бол ашиглалтын явцад хуримтлагдсан үнс нь анхдагч агаар ороход саад учруулахгүйгээр зохиомжлогдсон байна.

4.7.7.2 Ул ширэмний нүхээр унасан үнсийг бүрэн цуглуулахын зэрэгцээ анхдагч агаарын урсгалд саад болохгүй байвал зохино.

4.7.7.3 Сав нь үнсээр бүрэн дүүрэх тохиолдолд зуухны ажиллагаанд нөлөөлөхгүй үнс, шааргыг аюулгүй, чөлөөтэй гаргах боломжтой байна.

4.7.8 Ул ширэм

Ул ширэм нь хөдөлгөөнтэй болон хөдөлгөөнгүй байж болно.

ТАЙЛБАР: Хөдөлгөөнтэй ул ширэмтэй зуухны ам болон үнсний татуурга хаалттай байхад үнс буулгах хөшүүрэг нь биеийн хүч шаардахгүй, хөнгөн ажиллагаатай байх ёстой.

4.7.9 Анхдагч болон хоёрдогч агаарыг тохируулах

Анхлагч агаарын өгөлтийг үнсний татуургын онгойлтоор болон хоёрдогч агаарын өгөлтийг зуухны ам ба түүний дээд хэсэг дэх нүхнүүдийг нээж, хаах замаар тохируулах боломжтой байна.

4.7.10 Утааны хийг хянах

Утааны яндангийн сойлтуур чөлөөтэй хөдөлж, хаах хэсэг нь нийт огтлолын 75 %-аас ихгүй буюу бүрэн таглахааргүй байвал зохино.

4.7.11 Утааны хийн тойруу шугам

Утааны хийн тойруу шугам (хүхээгний өмнөх сойлтуур хаалттай) нь хялбар ажиллагаатай байна. Бүрэн нээлттэй болон хаалттай байршил нь тогтвортой, тодорхойлоход хялбар байна.

4.8. Материалд тавигдах шаардлага

4.8.1 Зуухны үндсэн хийцийн гангийн зузаан 2 мм-ээс багагүй байна.

4.8.2 Зуухны ширмэн хийцэд тавигдах шаардлагыг 2- р хүснэгтээр харуулав.

2- р хүснэгт. Цутгуурын ширэмний механик шинж чанарын доод хязгаар

Цутгуурын саарал ширэм (EN 1561:1997 стандартын дагуу)	
Суналтын хүчдэл R_m	>150 Н/мм ²
Бат бөх чанар	160 HB-220 HB
Графитын хольцтой цутгуурын ширэм (EN 1563:1997 стандартын дагуу)	
Суналтын хүчдэл R_m	>400 Н/мм ²
Харьцангуй суналт	18% A_3

4.8.3 Зуухны галын хотлын доторлогоо нь галд тэсвэртэй, дулаан барих чадвартай байх ба түүний ханын зузаан 30 мм-ээс багагүй байхаар хийнэ. Шавар нь керамик эдлэл хийдэг наанги шороо байх нь тохиромжтой.

4.8.4 Ханан пийшинг барих тоосго нь хувийн жин, нягт, хөвсгөр чанар, гал болон зэврэлтэнд тэсвэртэй байдал нь MNS 392-99 стандартын шаардлага хангасан бүрэн шаталттай, дулаан өөртөө хурдан шингээж, дамжуулах чадвар өндөртэй байвал зохино.

5. Байгаль орчинд нөлөөлөх байдал буюу экологийн үзүүлэлтэнд тавигдах шаардлага

5.1 Агаар бохирдуулах бодисуудын зөвшөөрөгдөх дээд хэмжээг 3-р хүснэгтэнд үзүүлэв.

ТАЙЛБАР: Зууханд төрөл бүрийн хатуу түлш хэрэглэх тохиолдолд тэдгээрийн дулаан гаргах доод чадвараас хамаарч бохирдуулах бодисын ялгаралт харилцан адилгүй байдаг. Иймд тэдгээрийг хооронд нь харьцуулахын тулд жишмэл түлш гэсэн ойлголтыг хэрэглэдэг.

3-р хүснэгт. Бохирдуулах бодисуудын зөвшөөрөгдөх дээд хэмжээ

д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Зөвшөөрөгдөх хэмжээ	Тайлбар
1	Нийт тоос буюу TSP	мг/нм ³	130	
		мг/МДж	90	
		мг/кг.ж.т	1 850	
2	Нарийн ширхэглэгт тоосонцор- PM2.5	мг/нм ³	100	
		мг/МДж	70	
		мг/кг.ж.т	1 430	
3	Нүүрстөрөгчийн дутуу исэл (CO)	мг/нм ³	9 800	
		мг/МДж	6 800	
		мг/кг.ж.т	140 000	
4	Хүхрийн давхар исэл (SO ₂) болон хүхэрт нэгдэл	мг/нм ³	1 200	
		мг/МДж	850	
		мг/кг.ж.т	17 400	
5	Азотын исэл (NO _x)	мг/нм ³	700	
		мг/МДж	480	
		мг/кг.ж.т	9 800	

5.2 Дээрх хүснэгтэнд үзүүлсэн бохирдуулах бодисуудын хэмжих нэгжүүдийг дараах байдлаар хооронд нь шилжүүлж тооцно. Үүнд:

- туршилтаар мг/м³ – ээр хэмжсэн тохиолдолд 8-р бүлэгт үзүүлсэн тооцооны аргачлалын дагуу хэвийн нөхцөлд буюу мг/нм³ нэгжид шилжүүлнэ. Үүний дараа мг/нм³-ийг бусад нэгжид шилжүүлнэ.
- мг/нм³-ийг мг/МДж нэгжид шилжүүлэхдээ түүнийг нэг кг түлшний шаталтаас ялгарах угааны хийн хуурай эзэлхүүн (нм³/кг) ээр үржүүлж, жишмэл түлшний дулаан гаргах доод чадвар буюу илчлэг (МДж/кг) ба зуухны АҮК-д хуваана. Энд бид зуухны АҮК-ийг стандартаар 0,7-аас багагүй байх ёстой гэдгээр тооцож авсан.
- мг/нм³-ийг мг/кг.ж.т-д шилжүүлэхдээ нэг кг түлшний шаталтаас ялгарах угааны хийн хуурай эзэлхүүн (нм³/кг)-ээр үржүүлж тооцно.
- мг/кг.ж.т-д шилжүүлэхдээ мг/МДж-ийг жишмэл түлшний дулаан гаргах доод чадвар буюу илчлэг (МДж/кг), зуухны АҮК ($\eta_3=0,7$)-оор үржүүлж гаргана.
- мг/нм³ нэгжийг гаргахдаа мг/кг-ийг нэг кг түлшний шаталтаас ялгарах угааны хийн хуурай эзэлхүүн (нм³/кг)-д хувааж тооцно.

6. Аюулгүй ажиллагааны шаардлага

6.1 Үйлдвэрлэгч зуухыг мэргэжлийн өндөр түвшинд зохион бүтээж үйлдвэрлэн итгэмжлэгдсэн лаборатори буюу эрх бүхий мэргэжлийн байгууллагаар туршуулан дүгнэлт гаргуулж, Мэргэжлийн хяналтын газар, Гамшиг судлалын лабораторийн дүгнэлт зэргийг үндэслэн Монгол улсын тохирлын гэрчилгээ авч баталгаажуулсан байх бөгөөд худалдаалж буй зуухнуудад аюулгүй ажиллагааны ба ашиглалтын зааврыг дагалдуулан хэрэглэгчдэд хүлээлгэн өгсөн байх ёстой.

6.2 Зуухны ажиллагааны үед түүний гадна гадаргуугийн температур 140 °C-ээс багагүй, 400 °C-ээс ихгүй байвал зохино. Харин хүний гар хүрэх хэсгийн гадаргуугийн

температур тасалгааны агаарын температураас дараах заасан хэмжээнээс ихгүй илүү байна.

Үүнд:

- а. металийн хувьд 35 °С;
- б. шил шаазан, паалан, эдгээртэй ижил материалын хувьд 45 °С;
- с. Хуванцар, резин, модны хувьд 60 °С.

ТАЙЛБАР: Хэрэв энэ температур дээрх утгаас өндөр байх тохиолдолд аюулгүй ажиллагааг хангахад шаардлагатай хамгаалах хэрэгсэл ашиглахыг аюулгүй ажиллагааны зааварт тусгасан байх хэрэгтэй.

6.3 Зуухны ашиглалтын үед халуун гадаргууд хүрч түлэгдэж, гэмтэхгүй байх талаар заавар, зөвлөмжийг ашиглалт, аюулгүй ажиллагааны зааварт тусгасан байна.

6.4 Зуухны ам нь нягт хаагддаг, үнсний тосгуур нь тал бүрээсээ сайн битүүмжлэгдсэн байна. Зуухны ам, агаар сорох нүхээр улайссан түлшний хэсэг буюу үнс гадагш унахаас зуухыг бүрэн хамгаалж зохион бүтээсэн байна.

6.5 Ханан пийшингийн гадна гадарга ан цав, хагархайгүй, гадаргуу дээрх хамгийн дээд температурыг (90⁰С-ээс-95⁰С) хангаж, галын аюулгүйн болон ариун цэврийн зөвшөөрөгдсөн нормоос хэтрэхгүй, оршин суугчдын эрүүл ахуй, сууцны дотоод орчин үзэмжинд сөрөг нөлөөгүй байх ёстой.

6.6 Ханан пийшин нь ашиглалтын үед шаталтаас үүссэн нүүрстөрөгчийн дутуу ислийг хуримтлуулах болон өндөр даралт бий болгон задарч оршин суугчдын амь насанд аюул эрсдэл учруулахааргүй байна.

6.7 Аливаа хэрэглэгч буюу захиалагч үйлдвэрлэгчээс зуухыг туршиж шалгасан, чанарын баталгаажуулалт шаардах, үнэлэх, үнэн зөв мэдээлэл, лавлагаа авах эрхтэй.

7 Турших арга

7.1 Зуухны туршилтыг зориулалтын лабораторит болон ахуйн нөхцөлд хийж болох бөгөөд зориулалтын баталгаажсан өндөр нарийвчлал бүхий хэмжих хэрэгсэл ашиглана. Туршилт хийхийн тулд янданд утааны хийн бүтэц тодорхойлох хэмжүүрийн анхдагчийг байрлуулах нүх гаргасан байна. Туршилтаар түлшний зарцуулалт, зуухны чадал, түүний ашигт үйлийн коэффициент болон утааны хийн зарцуулалт, температур, бохирдуулах бодисуудын хэмжээг тодорхойлно.

7.2 Турших зуух нь энэхүү стандартад заасан техникийн ерөнхий ба аюулгүй ажиллагааны шаардлагуудыг хангасан байна.

7.3 Хэмжилт хийх дараалал

7.3.1 Зуухыг жинлэх;

7.3.2 Галлах ба туршилтанд хэрэглэх түлшийг жинлэж бэлтгэх;

7.3.3 Бүх хэмжих хэрэгслийг хэмжилтийн цэгүүдэд байрлуулж, шалгаж тохируулах;

7.3.4 Зууханд бэлтгэсэн түлшийг хийж, жинлэх;

7.3.5 Зуухыг галлах;

7.3.6 Хэмжилтийг эхлэх;

7.3.7 Хэмжилтийн явцын тэмдэглэл хөтлөх;

7.3.8 Хэмжилтийг хянаж, туршилтыг дуусгах.

7.4 Туршилтанд ашиглах хэмжих хэрэгслүүд итгэмжлэгдсэн лабораториор баталгаажсан байхын зэрэгцээ дараах шаардлагыг хангасан байна.

7.5 Туршилтанд хэрэглэсэн түлш, үүссэн үнснээс дээж авч лабораторт шинжлүүлэн дараах үзүүлэлтүүдийг тодорхойлно.

- a. Түлшний илчлэг (Q_i^r), дэгдэмхий бодис (V^{daf}), чийглэг (W^r), үнслэг (A^r);
- b. Элементийн бүтэц (C^r, H^r, O^r, N^r, S^r);
- c. Үнс, шаарга дахь шатамхай бодисын хэмжээ ($G_{ш}, G_{пр}, G_{ун}$).

4-р хүснэгт. Хэмжих хэрэгсэлд тавигдах шаардлага

д.д	Хэмжүүрийн зориулалт	Хэмжих үзүүлэлт	Техникийн шаардлага
1	Жин	Зуух, түлшний жин	± 2
2	Температур хэмжих	Дөл, утааны хий ба зуухны гадаргуугийн температур	1°C
3	Утааны хийн найрлага дахь агаар бохирдуулах бодисыг хэмжих	Нүүрстөрөгчийн давхар исэл, CO ₂	Хэмжих хязгаар 0...20 % Нарийвчлал 0,1 %
		Хүчилтөрөгч, O ₂	Хэмжих хязгаар 0...21 % Нарийвчлал 0,1 %
		Нүүрстөрөгчийн дутуу исэл, CO	Хэмжих хязгаар 0...3 000 мг/м ³ Нарийвчлал ± 12 мг/м ³
		Азотын дан исэл, NO	Хэмжих хязгаар 0...5 000 мг/м ³ Нарийвчлал ± 15 мг/м ³
		Азотын давхар исэл, NO ₂	Хэмжих хязгаар 0...2 000 мг/м ³ Нарийвчлал ± 10 мг/м ³
		Азотын исэл, NO _x	Хэмжих хязгаар 0...5 000 мг/м ³ Нарийвчлал ± 15 мг/м ³
		Хүхрийн давхар исэл, SO ₂	Хэмжих хязгаар 0...5 000 мг/м ³ Нарийвчлал ± 15 мг/м ³
		Үнс буюу тоосонцор	Хэмжих хязгаар 0...3 000 мг/м ³ Нарийвчлал ± 12 мг/м ³
		Утааны температур, °C	Хэмжих хязгаар 0...800 °C Нарийвчлал 0,1 °C
		Илүүдэл агаарын коэффициент	Хэмжих хязгаар 0...10 Нарийвчлал 0,1

8. Туршилтын үр дүнг боловсруулах аргачлал

Туршилтын үеийн хэмжилтийн үр дүнг дараах аргачлалын дагуу боловсруулан шаардлагатай үзүүлэлтүүдийг тодорхойлно. Үүнд:

8.1 Туршилт хэмжилтийн үр дүнг ашиглан утаатай алдах дулааныг дараах томъёогоор тодорхойлно.

$$Q_2 = (t_a - t_{yt}) \times \left[\frac{C_{c.yx} \times (C - C_y)}{0.536 \times (CO + CO_2)} \right] + \left[C_{c.H_2O} \times 1.224 \times (9H + W) / 100 \right]$$

$$q_2 = 100 \times Q_2 / (Q_i^r) \tag{2}$$

Энд: t_{yt} - зуухнаас гарах утааны хийн температур, °C;

t_a - тасалгааны агаарын температур, °C;

$C_{c.yx}$ - стандарт нөхцөл дэх хуурай утааны хийн дулаан багтаамж, кДж/(Кхм³);

C, C_y - түлшний ажлын масс дахь ба үнсэнд үлдсэн нүүрстөрөгчийн агууламж, %;

CO, CO₂- хуурай утааны хий дэх нүүрстөрөгчийн дутуу ба давхар ислийн агууламж, %;

$C_{c.H_2O}$ - стандарт нөхцөл дэх хуурай утааны хий дэх усны уурын дулаан багтаамж, кДж/(Кхм³);

H, W- түлшний ажлын масс дахь устөрөгч ба чийглэгийн агууламж, %;

Q_i^r - түлшний илчлэг буюу дулаан гаргах доод чадвар, кДж/кг.

8.2 Стандарт нөхцөл дэх хуурай утааны хувийн дулаан багтаамж.

$$c_{c.yx} = 3.6 \left(0.361 + 0.008 \left(\frac{t_{yt}}{1000} \right) + 0.034 \left(\frac{t_{yt}}{1000} \right)^2 + \left(0.085 + 0.19 \left(\frac{t_{yt}}{1000} \right) - 0.14 \left(\frac{t_{yt}}{1000} \right)^2 \right) \left(\frac{CO_2}{100} \right) + \left(0.03 + \left(\frac{t_{yt}}{1000} \right) - 0.2 \left(\frac{t_{yt}}{1000} \right)^2 \right) \left(\frac{CO_2}{100} \right) \right) \tag{3}$$

8.3 Утааны хий дэх усны уурын хувийн дулаан багтаамж.

$$C_{c.H2O} = 3.6 \left(0.414 + 0.038 \left(\frac{t_{yt}}{1000} \right) + 0.034 \left(\frac{t_{yt}}{1000} \right)^2 \right) \quad (4)$$

8.4 Утааны хийн шинжилгээгээр тодорхойлсон нүүрстөрөгчийн дутуу исэл, устөрөгчийн хэмжээгээр химийн дутуу шаталтаас үүсэх дулааны алдагдлыг дараах томъёогоор тодорхойлно.

$$Q_3 = 12644 \times CO(C - C_Y) / [0.536(CO_2 + CO) \times 100] \\ q_3 = 100 \times Q_3 / Q_i^r \quad (5)$$

8.5 Туршилтын явцад нүүрсний шаталтаас үүсч байгаа шаарга, (ул ширэмний завсраар унасан нүүрс), үнсний сорьцийг лабораторид шинжлэн тэдгээрт агуулагдаж байгаа шатамхай хэсгийн хэмжээг тодорхойлж, түүнд үндэслэн механик дутуу шаталтаас үүсэх дулааны алдагдлыг дараах томъёогоор тодорхойлно.

$$q_4 = \frac{m_H}{B \cdot \tau} \times 100 \% \quad (6)$$

Энд: m_H – туршилтын хугацаанд зууханд үлдсэн үнсэн дэх шатаагүй нүүрсний масс, кг;

B – зууханд шатаасан түлшний хэмжээ, кг;

τ – туршилтын нийт хугацаа, ц.

$$m_H = m_Y \frac{100 - A}{100} \quad (7)$$

Энд: m_Y – туршилтын хугацаанд гарсан үлдэгдлийн масс, кг;

A – шатаж дууссан хэсэг дэх үнслэгийн хувь, %.

8.6 Зуухны дулааны алдагдлуудыг тодорхойлсны үндсэн дээр түүний АҮК-ийг урвуу балансын аргаар тодорхойлно.

$$\eta = 100 - q_2 - q_3 - q_4 \quad (8)$$

8.7 Зуухны дулааны чадал, кВт.

$$N = (B \times Q_i^r \times \eta) / (100 \times 3600) \quad (9)$$

8.8 Зуухны түлшний зарцуулалт, кг/ц.

$$B = ((m + m_r \times \left(\frac{Q_i^{rc}}{Q_i^r} \right) - m_Y) / \tau \quad (10)$$

Энд: m, m_r – ажлын ба галлагааны түлшний масс, кг;

Q_i^r , Q_i^{rc} – ажлын ба галлагааны түлшний дулаан гаргах доод чадвар, МЖ/кг;

m_Y – шатаагүй үлдсэн хэсгийн масс, кг;

τ – туршилт үргэлжлэх хугацаа.

9. Туршилтын үр дүнгийн зөвшөөрөх алдаа

Туршилтыг 3-аас доошгүй удаа хийж үр дүнг жингийн болон арифметик дундажаар авна.

9.1. Үр дүнгүүд нь зуухны чадал (N), зуухны түлшний зарцуулалт (B), ашигт үйлийн коэффициент (η) зэргийг тодорхойлоход 2 %, бохирдуулах бодисуудыг тодорхойлоход 10- аас дээш хувиар зөрж байвал туршилтыг дахин хийнэ. Давтан хийсэн туршилтын үр дүн эцсийнх байна.

9.2. Үр дүнг боловсруулах арга MNS 2659: 1991, үр дүнгийн алдааг үнэлэх арга MNS2660:1993 стандартуудтай тус тус тохирч байх ёстой.

10. Туршилтын үр дүнг хэвийн нөхцөлд шилжүүлэх аргачлал

10.1 Зуухнаас гарч байгаа утааны хийн найрлага, илүүдэл агаарын коэффициент зэргийн хийн шинжлүүрийн хэмжилтийн үр дүнд тулгуурлан утааны хий дэх NO_x , SO_2 , CO ба тоосонцорын агууламжийг тодорхойлно.

10.2 Тухайн хэмжүүрийн заалтын нэгжээс хамааран утааны найрлага дахь агаар бохирдуулах бодисын агууламжийг “ppm” буюу $\text{мг}/\text{м}^3$ -ээр хэмжинэ.

10.3 Утааны найрлага дахь агаар бохирдуулах бодисын агууламжийн хэмжиж тодорхойлсон утгыг дараах илэрхийллээр хэвийн нөхцөлд шилжүүлэхдээ утааны хий дэх хүчилтөрөгчийн хэмжээ 10.0 % байх үеийн илүүдэл агаарын коэффициентийн утгыг $\alpha=1.9$ –аар авч тооцоолно.

10.4 Эзлэхүүний агууламж буюу ppm-ээр илэрхийлсэн тохиолдолд

$$C_v^{xH} = C_v [(V_{xx}^0 + (\alpha - 1)V_a^0)/(V_{xx}^0 + (1.9 - 1)V_a^0)] \quad (11)$$

10.5 Массын агууламж буюу $\text{мг}/\text{м}^3$ -ээр илэрхийлсэн тохиолдолд

$$C^{xH} = C_o \left[\left(\frac{p}{p_0} \right) \left(\frac{p_0}{p} \right) \left(\frac{V_{xx}^0 + (\alpha - 1)V_a^0}{V_{xx}^0 + (1.9 - 1)V_a^0} \right) \right] \quad (12)$$

Энд: C_v - утааны хийн найрлага дахь агаар бохирдуулах бодисын эзлэхүүний агууламжийн хэмжилтээр тодорхойлсон дундаж утга, ppm;

C_d - утааны найрлага дахь агаар бохирдуулах бодисын массын агууламжийн хэмжилтээр тодорхойлсон дундаж утга, $\text{мг}/\text{м}^3$;

V_{xx}^0 - түлшний шаталтаас үүсэх хуурай хийн онолын эзлэхүүн, $\text{нм}^3/\text{кг}$;

α - илүүдэл агаарын коэффициент;

V_a^0 - 1 кг түлшний шаталтанд шаардлагатай агаарын онолын эзлэхүүн, $\text{нм}^3/\text{кг}$;

$B=101325$ Па –хэвийн нөхцөл дэх агаарын даралт, Па;

t - утааны температур, $^{\circ}\text{C}$;

p - орчны агаарын буюу утааны даралт, Па.

10.6 Агаар бохирдуулах бодисуудын гаралтын хэмжээг дараах илэрхийллээр тодорхойлно.

10.6.1 1кг түлшний шаталтаас үүсэх утааны найрлага дахь агаар бохирдуулах бодисын хэмжээ, $\text{мг}/(\text{кг.т})$ буюу $\text{мг}/(\text{кг.ж.т})$

$$m = C_d \times V_{x,x} \times 10^{-3} \quad \text{буюу} \quad m = C_d \times V_{x,x} \times (Q_{ж.т}/Q_i^t) \times 10^{-3} \quad (18)$$

Энд: C_d - утааны найрлага дахь агаар бохирдуулах бодисын массын агууламжийн хэмжилтээр тодорхойлсон дундаж утга, $\text{мг}/\text{м}^3$;

$V_{x,x}=V_{xx}^0 + (\alpha - 1)V_a^0$ - 1 кг түлшний шаталтаас үүсэх хуурай хийн бодит эзлэхүүн, $\text{нм}^3/\text{кг}$;

$Q_{ж.т}$ - 1 кг жишмэл түлшний шаталтаас ялгарах дулаан (илчлэг), МДж/кг;

Q_i^t - 1 кг бодит түлшний шаталтаас ялгарах дулаан (илчлэг), МДж/кг.

10.6.2 Зуухны гадна гадаргуугаас гэрийн буюу барилгын дотор агаарт өгөх 1 МДж дулаанд харгалзах агаар бохирдуулах бодисын хэмжээ, $\text{мг}/\text{МДж}$

$$K = C_d \times V_{x,x} \times 10^{-3} / (Q_i^t / \eta) \quad (14)$$

10.6.3 Нэгж хугацаанд түлшний шаталтаас үүсэх агаар бохирдуулах бодисын хэмжээ, $\text{г}/\text{с}$

$$M = C_d \times B \times V_{x,x} \times 10^{-3} \quad (15)$$

Энд: B - бодит түлшний секундын зарцуулалт, $\text{кг}/\text{с}$.

11. Туршилтын үр дүнг тайлагнах

11.1. Хүлээн авах – хүлээлгэн өгөх, ээлжит болон загварын туршилтын үр дүнг дараах мэдээлэл агуулсан протокол үйлдэж албан ёсны болгоно.

- Үйлдвэрлэгчийн нэр;
- Зуухны үйлдвэрийн дугаар;
- Зуухны холбогдох баримт бичиг;
- Туршилтанд хэрэглэсэн түлшний төрөл;
- Туршилтын нөхцөл ба арга;
- Энэ стандартын тэмдэглэгээ ба нормчилсон үзүүлэлт;

- h. Туршилтын үр дүн;
- g. Дүгнэлт;
- i. Туршилт хийсэн огноо;
- j. Туршилт хийсэн хүний нэр, гарын үсэг.

12. Хаяглах

12.1. Зуух тус бүрд шошго хэрэглэх бөгөөд түүнд дараах зүйлийг бичнэ.

Үүнд:

- a. Үйлдвэрлэгчийн нэр, оршин байгаа газрын нэр;
- b. Үйлдвэрлэсэн огноо;
- c. Зуухны марк;
- d. Ашиглах заавар (ямар түлш хэрэглэх тухай болон аюулгүйн нөхцөл);
- e. Энэхүү стандартын тэмдэглэгээ мөн Үндэсний тохирлын тэмдэг (дүрс) хэрэглэхээр авсан бол шошго дээр ашиглах;
- f. Баталгаат хугацаа;

А хавсралт

Хүснэгт А1. Стандартад хэрэглэсэн үзүүлэлтүүдийн тэмдэглэгээ, хэмжих нэгж

№	Тэмдэглэгээ	Тодорхойлолт	Нэгж
1	A	Шатаагүй үлдсэн хэсэг дэх үнслэгийн хувь,	%.
2	A'	Ажлын түлшний үнслэг	%
3	B	Хэвийн нөхцөл дэх агаарын даралт	Па
4	Bг	Түлшний зарцуулалт	Кг
5	b	Бодит түлшний секундын зарцуулалт	кг/с
6	C'	Түлшний ажлын масс дахь нүүрстөрөгчийн агууламж	%
7	C _{c,y,x}	Стандарт нөхцөл дэх хуурай утааны хийн дулаан багтаамж	кДж/(Кхм ³)
8	C _γ	Үнсэнд үлдсэн нүүрстөрөгчийн агууламж	%
9	C _{c,H2O}	Стандарт нөхцөл дэх утааны хий дэх усны уурын дулаан багтаамж	кДж/(Кхм ³)
10	C _n	Бохирдуулах бодисын хэвийн нөхцөлд шилжүүлсэн агууламж	мг/нм ³
11	C _v	Утааны хийн найрлага дахь агаар бохирдуулах бодисын эзлэхүүний агууламжийн хэмжилтээр тодорхойлсон дундаж утга	Ppm
12	C _d	Утааны найрлага дахь агаар бохирдуулах бодисын массын агууламжийн хэмжилтээр тодорхойлсон дундаж утга	мг/м ³
13	CO	Хуурай утааны хий дэх нүүрстөрөгчийн дутуу ислийн агууламж	%
14	CO ₂	Хуурай утааны хий дэх нүүрстөрөгчийн давхар ислийн агууламж	%
15	G _ш	Шаарга дахь шатамхай хэсэг	%
16	G _{ун}	Дэгдэмхий үнсэн дэх шатамхай хэсэг	%
17	H'	Түлшний ажлын масс дахь устөрөгчийн агууламж	%
18	K	Зуухны гадна гадаргуугаас гэрийн буюу барилгын дотор агаарт өгөх 1 МДж дулаанд харгалзах агаар бохирдуулах бодисын хэмжээ	мг/МДж
19	K ₁	Туршилтаар тодорхойлогдох коэффициент	-
20	m _n	Туршилтын дараа зууханд үлдсэн үнсэн дэх шатаагүй нүүрсний жин	кг
21	m _γ	Туршилтын хугацаанд гарсан үлдэгдлийн масс	кг
22	m _a	Ажлын түлшний масс	кг
23	m _r	Галлах түлшний масс	кг
24	M	1кг түлшний шаталтаас үүсэх агаар бохирдуулах бодисын хэмжээ	мг/(кг.ж.т)
25	M	Нэгж хугацаанд түлшний шаталтаас үүсэх агаар бохирдуулах бодисын хэмжээ	г/с
26	N	Зуухны дулааны чадал	кВт

27	N^r	Түлшний ажлын масс дахь азотын агууламж	%
28	NO_x	Азотын исэл	-
29	O^r	Түлшний ажлын масс дахь хүчилтөрөгчийн агууламж	%
30	P	Орчны агаарын буюу утааны даралт	Па
31	Q_i^r	1 кг түлшний шаталтаас ялгарах дулаан (илчлэг буюу дулаан гаргах доод чадвар)	МДж/кг
32	Q_i^{nr}	Галлах түлшний илчлэг буюу дулаан гаргах доод чадвар	МДж/кг
33	$Q_{ж.т}$	1 кг жишмэл түлшний шаталтаас ялгарах дулаан (илчлэг буюу дулаан гаргах доод чадвар)	МДж/кг
34	Q_2	Утааны хийтэй алдах дулаан	кДж/кг
35	q_2	Утааны хийтэй алдах дулааны хувь	%
36	q_3	Химийн дутуу шаталтаас үүсэх дулааны алдагдлын хувь	%
37	q_4	Механикийн дутуу шаталтаас үүсэх дулааны алдагдлын хувь	%
38	RO_2	Шаталтын бүтээгдэхүүн дэх гурван атомт хийн эзлэхүүний хувь	%
39	S^r	Түлшний ажлын масс дахь хүхрийн агууламж	%
40	SO_2	Хүхрийн исэл	-
41	t_{yt}	Зуухнаас гарах утааны хийн температур	°C
42	t_a	Тасалгааны агаарын температур	°C
43	V^{daf}	Дэгдэмхий бодис	%
44	V_a^o	1 кг түлшний шаталтанд шаардлагатай агаарын онолын эзлэхүүн,	нм ³ /кг
45	$V_{x.x}$	1 кг түлшний шаталтаас үүсэх хуурай хийн бодит эзлэхүүн	нм ³ /кг
46	V_{xx}^o	Түлшний шаталтаас үүсэх хуурай хийн онолын эзлэхүүн	нм ³ /кг
47	W^r	Түлшний чийглэг	%
48	α	Илүүдэл агаарын коэффициент	-
49	τ	Туршилтын нийт хугацаа	цаг
50	η	Зуухны ашигт үйлийн коэффициент (АҮК)	%

Ном зүй

- [1]. MNS 1-1: 2006, Монгол улсын үндэсний стандартчиллын тогтолцоо. 1-р хэсэг: Техникийн ажлын журам.
- [2]. MNS 1-2: 2006, Монгол улсын үндэсний стандартчиллын тогтолцоо. 2-р хэсэг: Стандартын бүтэц ба боловсруулах.
- [3]. Стандартыг хэрхэн бичих вэ? Стандарт боловсруулагчдад зориулсан зөвлөмж.
- [4]. ISO/IEC Directives Part 1. 2016, Contains the Final version and The Redline Version. Procedures for the technical work.

- [5]. ISO/IEC Directives Part 2. 2016, Principles and rules for the structure and drafting of ISO and IEC documents.
- [6]. MNS 5216:2002, Хатуу түлшээр ажилладаг гэрийн зуух. Техникийн ерөнхий шаардлага
- [7]. MNS 5216-1:2011, Ахуйн хэрэглээний зуух. Техникийн ерөнхий шаардлага
- [8]. MNS 5458:2005, Халаалтын ба гэрийн зуухны яндангаар гарах утааны найрлага дахь агаар бохирдуулагч бодисын хүлцэх дээд хэмжээ ба хэмжих арга;
- [9]. MNS 5568:2005, Шингэн түлшээр ажилладаг ахуйн хэрэглээний зуух. Техникийн ерөнхий шаардлага;
- [10]. BS EN 13240:2001, Хатуу түлшээр ажилладаг гэрийн зуух. Техникийн ерөнхий шаардлага ба шалгах арга.
- [11]. GB/T XXXXX-2016. National Standard of P.R.China Clean biomass cookstove.
- [12]. АХБ ТТ No. 7462-МОН төслийн эцсийн тайлан: Улаанбаатар цэвэр агаар төсөл, 2011 оны 7 сарын 18;
- [13]. Стандарчилал, тохиролын үнэлгээний тухай хууль. 2003 оны 05-р сарын 15-ны өдөр.
- [14]. Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хууль. 1994 оны 12-р сарын 22-ны өдөр.
- [15]. Е.М. Купряков "Стандартизация и качество промышленной продукции" Учебник. Москва., 1985 г. 288 ст.
- [16]. ISO/FDIS 16993: 2016 (E) Annex C. Guidline for the use of validation parameters.
- [17]. Дэлхийн банк групп. Монгол улс – “Цэвэр зуух” үндэсний стратеги Монгол улсын цэвэр зуухны тогтвортой зах зээлийн шилжилтийг эцэслэх нь тайлан. УБ хот. 2014 он.
- [18]. ЦУОШГ-аас 2015 онд хийсэн Агаарын бохирдолын суурин эх үүсвэрийн нэгдсэн тоо, бүртгэл. УБ хот.
- [19]. Монгол гэрийн зууханд тогтоосон ашигтай горимоор дулаан техникийн туршилт хийх. Төслийн тайлан. ДБ-ны санхүүжилттэй төсөл. 2004 он.
- [20]. Ханын пийшин бүхий гэрийн зуухны АҮК тодорхойлох төсөл. ДБ-ны санхүүжилттэй төсөл. УБ: 2004 он.
- [21]. Field-Testing Services For Alternative Fuels in Approved stoves. Final Report. Prerformed This Work Under TheContract With Energy and Environmental Project of The MCA-Mongolia. Building Energy Efficiency Center of MUST.March 2012. 72 p.
- [22]. Монгол улс. Нийслэлийн агаарын чанарын алба. Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах хяналтын чадавхыг бэхжүүлэх төсөл. Төслийн эцсийн тайлан. Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА) “Сүүри-Кейкакү” ХК, 2013 оны 3 сар.
- [23]. Монгол улс. Нийслэлийн агаарын чанарын алба. Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах хяналтын чадавхыг бэхжүүлэх төсөл. Төслийн эцсийн тайлан. Техникийн гарын авлага. Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА) “Сүүри-Кейкакү” ХК, 2013 оны 3 сар
- [24]. Stove testing report under the assignment Technical assismence for Capacity Building to the stove Emission Testing Laboratory and The stove Development Center prepared for World Bank/International Development Association and Ulaanbaatar Clean Air Project, Project Management Unit prepared by Mon-Energy Consult LLC and MUST. 2013, July.
- [25]. STOVE TESTING REPORT under the assignment for Technical assistance for Capacity Building to the stove Emissions and efficiency Testing Laboratory and The stove Development Center. Prepared for World Bank/ International Development Association and Ulaanbaatar Clean Air Project, Project Management Unit. July 2014. p. 88.
- [26]. Зуухны хорт ялгаралт, үр ашгийг тодорхойлох туршилтын лаборатор болон зуух хөгжлийн төвийн чадавхыг бэхжүүлэх ажил. Эцсийн тайлан. Мон-Энержи Консалт ХХК. 2016 он.

- [27]. Монгол улс. Нийслэлийн агаарын чанарын алба. Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах хяналтын чадавхыг бэхжүүлэх төсөл. (2-р үе шат) Төслийн явцын тайлан. Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА) “Сүүри-Кейкакү” ХК, 2016 оны 4 сар.
- [28]. Гэрийн зуухны туршилтын протокол. Зуухны туршилт, судалгааны лаборатори ба зуух хөгжүүлэх төвийн чадавхийг дээшлүүлэх техникийн туслалцаа. Төслийн дугаар: IDA5039-MN. Дэлхийн банк/Олон улсын хөнжлийн нийгэмлэг ба Улаанбаатар цэвэр агаарын төсөл, төслийг удирдах нэгж, Мон Энержи ХХК. 2015 .
- [29]. Гэрийн зуухны АҮК, хаягдлыг тодорхойлох туршилтын протокол. МСС. 2012 он.
- [30]. Measurement Good Practice Guide No 36. Estimating Uncertainties in Testing An intermediate Guide to Estimating and Reporting Uncertainty of Measurement in Testing. Keith Birch British Measurement and Testing Association. Teddington Middlesex, United Kingdom. TW11)NQ. ISSN 1368-6550. 2003. United Kingdom. TW11)NQ. ISSN 1368-6550. 2003.
- [31]. Guidelines on Methodologies for Source Emission Monitoring. Central Pollution Control Board (Ministry of Environment and Forests) Parivesh Bhawan, East Arjun Nagar, Delhi-110032 Website: www.cpcb.nic.in. CPCB. 200 Copies, 2012.
- [32]. Combustion Analysis Basics. An Overview of Measurement, Methods and Calculations Used in Combustion Analysis. Copyright 2004 by TSI incorporated.
- [33]. Дэлхийн банк. Монгол улс: “Улаанбаатар хотын захын ядуу гэр хороолол болон зарим хөдөө орон нутаг дахь халаалтын зуухны зах зээлийн чиг хандлага” судлагааны тайлан. Австралийн ОУХА. Монгол улсын цэвэр зуух санаачлага. 2013.01.21.
- [34]. Field-testing services for alternative fuels in approved stoves. Final report. Performed under the contract with energy and environmental project of the MCA-MONGOLIA building energy efficiency center of the MUST. March 2012.
- [35]. TA NO. 7462 – MON: Ulaanbaatar clean air project. Final report. Prepared for ADB submitted by Dalkia Energy Services Limited the Great Eastern Centre, Ryder Tower, 70, Nehru Place New Delhi 110019 24th Feb, 2011
- [36]. Нийслэлийн засаг даргын тамгын газар НАЧА- ны хэмжилтийн үр дүнгүүд. 2012-2015 он.
- [37]. P.Sharavnyamba- Wall stove consultant of the Project. Ulaanbaatar Clean Air Project. Recommendations for operation and safety of wall stove. 2014. 64 p.

ТӨГСӨВ.

Хавсралт 2

Contents

1 Foreword

2

2	Scope	3
3	Normative references	3
4	Terms and definitions	4
5	Technical requirements	7
6	Environmental requirements or the maximum acceptable level of pollutants in the flue gas.	9
7	Safety requirements	10
8	Test methods	10
9	Calculation methods	12
10	Permissible error of the test results	13
11	Methodology for transferring test results to the normal conditions	13
12	Test report	14
13	Labeling	14
14	Annex A	15
15	Bibliography	16

Foreword

Mongolian Agency for Standardization and Metrology is a member of the International Standardization Organization and fulfill the National standardization policy in a scope of its work with state and non government organizations.

